



УЛААНБААТАР  
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот

Авлигын эсрэг үйл ажиллагааны  
төлөвлөгөө батлах тухай

Компаний дүрмийн 8 дугаар зүйлийн 8.11.11, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн авлигын эсрэг үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлэх, шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг салбар, нэгж, хэлтэс, албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /Б.Баттушиг/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАЯРСАЙХАН

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 02 сарын 26 өдрийн 119 дугаар тушаалын хавсралт



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

- ❖ Энэхүү төлөвлөгөөг 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.
- ❖ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” болон “Төрийн байгууллага дахь авлигын эрсдлийн үнэлгээний аргачлал”-тай уялдуулсан болно.
- ❖ Энэхүү төлөвлөгөөний биелэлийн мэдээ, тайланг хариуцсан нэгж албан тушаалтан хагас, бүрэн жилээр 2019 оны 08 дугаар сарын 01, 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Захиргаа, хүний нөөцийн хэлтэст ирүүлнэ.

Д/д	Үйл ажиллагаа, түүний эрх зүйн үндэслэл	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх хугацаа, хуваарь	Хариуцах нэгж, албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан
1	2	3	4	5	6
Нэг. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр:					
1	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, журам, дүрмийн төсөлд ажилчдын болон сонирхогч бүлгийн саналыг тусгах арга хэмжээ авах  Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.	<ul style="list-style-type: none"> <li>- Төсөлд ажилчдын болон сонирхогч бүлгээс санал өгөх боломжоор хангах,</li> <li>- Ил тод байршуулах техникийн нөхцлийг бүрдүүлсэн байх,</li> <li>- Төслийн талаарх албан хаагчид болон бусад этгээдээс ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулах,</li> <li>- Эрх бүхий этгээдээр батлуулж, мөрдүүлэх арга хэмжээ авах.</li> </ul>	Тухай бүр	ЗХНХ, Журам, дүрмийн төслийг боловсруулж буй нэгж	МТХ, Бүх салбар, нэгж, хэлтэс, алба

1	2	3	4	5	6
2	<p>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг тогтмол мэдээлж байх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</li> <li>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн холбогдох заалтыг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлсэн байх,</li> <li>- Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх,</li> <li>- Байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны явцын талаарх мэдээлэл ил тод болсон байх.</li> <li>- Шилэн дансны мэдээллийн ил тод байдалд хяналт тавьж ажилласан байх.</li> </ul>	Тухай бүр	ЗХНХ, СБХ, ХҮА, ТЭЗХ буюу 2016 оны 01-р сарын 19-ны А/15 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хамаарна.	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба
3	<p>Байгууллагын дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж, албан хаагчдад мэдээллийг ил тод, шуурхай хүргэж ажиллах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- <a href="http://www.able.tog.mn">www.able.tog.mn</a> дотоод сүлжээнд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт албан хаагчдын хэрэгцээний мэдээллийг шуурхай байршуулан мэдээлж байх,</li> <li>- Дотоод сүлжээний системийг иж бүрнээр нь ашиглаж хэвших.</li> </ul>	Тухай бүр	МТХ	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба
4	<p>Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийж, мэдээллийн ил тод байдлыг хангах боломжийг бий болгох</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Компаний цахим хуудас хэвийн ажиллагаатай байх,</li> <li>- Хэлтсүүдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд мэдээлж байх,</li> <li>- Мэдээллийн баяжилт хийгдсэн байх.</li> </ul>	Тухай бүр	МТХ	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба

1	2	3	4	5	6
5	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ил тод байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээлэл нээлттэй, үр ашигтай, хүртээмжтэй байх,</li> <li>- Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байгууллагын үйл ажиллагааны явцыг олон нийтэд тогтмол мэдээлж хэвшсэн байх,</li> <li>- Байгууллагын цахим хуудас болон холбогдох бусад цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулсан байх,</li> <li>- Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг тогтмол хийх.</li> </ul>	Тухай бүр	МТХ, МА	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба
6	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Шалгуур үзүүлэлт, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт албан хаагчдад танилцуулсан байх,</li> <li>- Хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байх,</li> <li>- Шалгуур үзүүлэлтийг хангаж, үнэлгээнд хамрагдах.</li> <li>- Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байх.</li> </ul>	Тухай бүр	ЗХНХ	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба
7	<p>Компаний бүтцийн нэгж дэх ажлын байр, албан тушаалд нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч бүртгэн, АТГ-т хүргүүлж хянуулж хариуг авах ажлыг зохион байгуулах.</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хүлээн авч, бүртгэх,</li> <li>- АТГ-т хүргүүлэн хянуулах,</li> <li>- АТГ-аас ирүүлсэн ХАСУМ хянасан тухай албан бичгийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулах.</li> <li>- Нэр дэвшигчдийн ХАСУМ-ийг хянуулахаар ЭБАТ-д өгөх,</li> <li>- АТГ-ын дүгнэлтийг үндэслэн томилох шийдвэрийг гаргах ажлыг зохион байгуулах.</li> </ul>	Тухай бүр	ЭБАТ  Хүний нөөцийн мэргэжилтнүүд	АТГ

1	2	3	4	5	6
8	<p>Мэдүүлэг гаргагч албан хаагчдаас хөрөнгө орлогот их хэмжээний өөрчлөлт орсоноос хойш болон томилогдсоноос хойш 30 хоногт (2018*, 2018+) багтаан ХАСХОМ-ийг мэдүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3;</li> <li>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллагын мэдүүлэг гаргагчид (шинээр томилогдсон) ХАСХОМ-ээ хугацаанд нь гаргаж мэдүүлсэн байх,</li> <li>- Цахим системд баталгаажуулсан байх,</li> <li>- ЭБАТ-д цаасан сууриар мэдүүлгийг хүлээлгэж өгсөн ХАСХОМ-ын бүртгэлийг цахим системд оруулах,</li> <li>- Мэдүүлэг бүрдүүлэлтийн ажил цаг хугацаандаа зохион байгуулагдсан, зөрчилгүй байх.</li> </ul>	Тухай бүр	ЭБАТ	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнууд
9	<p>Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдлийг холбогдох албан хаагчдаас гаргуулан авч, мэдүүлэг бүрдүүлэлтийн системд бүртгэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.6.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох ажилчдаас мэдэгдлийг тухай бүр гаргуулан авах,</li> <li>- Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдэгдлийн мэдээллийг бүртгэн оруулсан байх,</li> <li>- Мэдээллийн санг үүсгэн хяналт тавьж ажиллах.</li> </ul>	Тухай бүр	ЭБАТ	Үнэлгээний хороо, Ажлын хэсэг, Шалгалтын комисс /Мөн сонирхлын зөрчилтэй гэж ойгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдүүлэх/
10	<p>Мэдүүлэг бүрдүүлэлтийн програм дахь “ЭБАТ” цэсний бүртгэлүүдийг тогтмол бүрэн хөтлөн мэдүүлэг, мэдэгдлийг хуулийн хугацаанд хүлээн авч, албан хаагчдад холбогдох зөвлөмж, арга зүйн туслалцаа үзүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5;</li> <li>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуульд заасан хугацаанд бүртгэл, бүрдүүлэлтийг хийж гүйцэтгэсэн байх,</li> <li>- Мэдүүлэг гаргагч албан хаагчдад хөрөнгө орлогод орсон их хэмжээний өөрчлөлт (2018+)-ийг хуулийн хугацаанд мэдүүлэх талаар санамж өгөх,</li> <li>- Заавар, зөвлөмжийг холбогдох мэргэжилтэнд хүргэж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах.</li> </ul>	Тухай бүр	ЭБАТ	-

1	2	3	4	5	6
12	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэр, албан бичгийн хэрэгжилтийг хангаж зохион байгуулалтын арга хэмжээ авах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Удирдлагуудад танилцуулан хэрэгжилтийг хангах,</li> <li>- Зөвлөмж, шийдвэрийн хэрэгжилтийг гарган холбогдох удирдлага, олон нийтэд танилцуулах.</li> </ul>	Тухай бүр	ЗХНХ	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба, АТГ
13	<p>Худалдан авах ажиллаганы ил тод байдлыг хангаж, тендер шалгаруулалтыг цахимаар зохион байгуулах, тендерт шалгарсан, шалгараагүй үндэслэл, тендерийн үр дүнг худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-д бүрэн оруулах, байгууллагын цахим хуудсанд тодорхой байршуулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1;</li> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</li> <li>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;</li> <li>• Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Цахим хуудсанд тендерийн үр дүнг мэдээлэхдээ ЗХНХ-ээр урьдчилан хянуулсны дүнд олон нийтэд мэдээлэх,</li> <li>- Цахим хуудаснаас мэдээллийг тодорхой авах боломжтой байх,</li> <li>- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байх.</li> <li>- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль болон Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын хэрэгжилт бүрэн хангагдсан байх</li> </ul>	Тухай бүр	ХҮА	МТХ

1	2	3	4	5	6
14	<p>Зохион байгуулах худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</li> <li>• Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4, 6.4.6;</li> <li>• Төрийн болон орон нут-гийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах урилгыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлсэн байх,</li> <li>- Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ төслийг цахим хуудсанд байршуулах,</li> <li>- Гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх заалт тусгах,</li> <li>- Гэрээ байгуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оруулах,</li> <li>- Мэдээллийн бааз үүсгэсэн байх.</li> </ul>	I, II улирал	ХҮА	ЗХНХ
15	<p>Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсанд мэдээлж, хэвших</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2;</li> <li>• Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3;</li> <li>• Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомд-лын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр),</li> <li>- Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан ажилтны нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах</li> <li>- Улирлын мэдээ гаргаж, шийдвэрлэлтийн байдлыг улирлаар мэдээлсэн байх,</li> <li>- Цахим хуудсанд байршуулан мэдээлэх.</li> </ul>	Тухай бүр	ХХА, ЗХНХ, ХҮТ-үүд, ТТ-үүд	-

1	2	3	4	5	6
16	<p>Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр (тушаал, тогтоол)-ийг цахим хуудсанд байршуулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх (цахим хуудсаар),</li> <li>- Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж (хуульчилсан акт), дүрэм, журам, зааврыг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байх.</li> </ul>	Тухай бүр	ЗХНХ, тухай шийдвэрийн төслийг боловсруулан батлуулсан нэгж, салбар, төвүүд	МТХ
17	<p>Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ-ын үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ТББ-ын үйл ажиллагааг дэмжих,</li> <li>- Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга (уриа, уриалга, мэдэгдэл, амлалт г.м)-д нэгдэх.</li> </ul>	Тухай бүр	ЗХНХ	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба, АТГ
18	<p>Авлигад өртөх эрсдэлтэй албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах,</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12;</li> <li>• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны үндсэн дээр эрсдэлтэй ажлын байрны жагсаалтыг гаргах,</li> <li>- Албан хаагчдаас санал авах,</li> <li>- Тушаалаар батлан гаргаж, байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээлэх.</li> </ul>	Х сард	ЗХНХ,	Бүх салбар, нэгж, хэлтэс, алба,
19	<p>Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн тоог нэмэгдүүлэх, бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрчилгээ эзэмшигчийн нэрсийн жагсаалт, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</li> </ul>	Тухай бүр	ХҮА	ЗХНХ



1	2	3	4	5	6
Хоёр. Сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:					
20	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар Үнэлгээний хороонд ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллүүдэд уулзалт, семинар зохион байгуулах.</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Уулзалт, семинарын зохион байгуулах,</li> <li>-</li> </ul>	XII сард	ЗХЗХ, ХҮА	ХҮА
21	<p>Нийт албан хаагчдын авлигын эсрэг хууль тогтоомж, мэдүүлэг, мэдэгдэл гаргах талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын сэдвийг АТГ-тай хамтран тогтох,</li> <li>Сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан байх.</li> </ul>	IV-V сард	ЭБАТ, ЗХНХ	АТГ-ын УССГХ, ХШДШХ
22	<p>Шударга ёс, ёс зүйн асуудал хөндсөн сэдвээр лекц уншуулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Лекторыг сонгон холбогдож, лекц унших товыг тогтох,</li> <li>Лекцийг тогтсон хугацаанд уншуулах,</li> <li>Нийт албан хаагчдыг хамруулсан байх.</li> </ul>	X, XI сард	ЗХНХ	Ёс зүйн хороо, ЭБАТ
23	<p>Шинэ ажилтны сургалт болон сар, жилийн давтан зааварчилгааны сургалтын хуваарьт Авлигын эсрэг соён гэгээрүүлэх асуудлаар тусгаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4; 6 дугаар зүйлийн 6.1.8.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын сэдвийг АТГ-тай хамтран тогтох,</li> <li>Сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан байх.</li> </ul>	Жилийн турш	ЭБАТ, сургалтын инженер	ЗХНХ